



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 03 өдөр

Дугаар 1106

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн 2024 оны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 56 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.3-д тусгагдсан “Хог хаягдлын менежментийг сайжруулах (техник, тоног төхөөрөмж) Жаргалант сум” төсөл, арга хэмжээний зураг төсөв, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг үндэслэлтэй боловсруулж, батлуулан, худалдан авах ажиллагааг зарлах ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, гуравдугаар хавсралтын 2.4-д тусгагдсан “Ногоон байгууламж, бүтээн байгуулалт, тохижилт, (Жаргалант сум)”, аймгийн Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний тавдугаар хавсралтын 1.2-т туссан “Ногоон байгууламж, бүтээн байгуулалт, тохижилт” төсөл арга хэмжээний зураг төсөв, ажлын даалгавар боловсруулах ажлын хэсгийг хоёрдугаар хавсралтаар тус тус байгуулсугай.

2. Дээрх төсөл арга хэмжээний ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолтыг үндэслэлтэй боловсруулж, баталгаажуулсны үндсэн дээр худалдан авах ажиллагааг 05 дугаар сарын 01-ний дотор холбогдох хууль, журмын дагуу ил тод, нээлттэй, шуурхай зохион байгуулж, гүйцэтгэгчийг шалгаруулан гэрээ байгуулж, ашиглалтад хүлээн авах арга хэмжээ авч, үр дүнг 08 дугаар сарын 28-ны дотор тайлагнахыг Засаг даргын орлогч /Э.Уртнасан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.АМАРСАНАА

8400001 0030

Zab A/06 kh

Засаг даргын 2025 оны  
01 дүгээр сарын 03-ны өдрийн  
А/06 дугаар захирамжийн  
хоёрдугаар хавсралт

НОГООН БАЙГУУЛАМЖ, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ТОХИЖИЛТ,  
(ЖАРГАЛАНТ СУМ) ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗУРАГ ТӨСӨВ,  
АЖЛЫН ДААЛГАВАР БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн  
ахлагч:

Э.Уртнасан (Засаг даргын орлогч)

Б.Амартүвшин (Жаргалант сумын Засаг дарга)

Б.Түмэндэмбэрэл (Аймгийн Ерөнхий архитекторын албан  
үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Б.Цогтсайхан (Газрын харилцаа, барилга, хот  
байгуулалтын газрын Кадастрын хэлтсийн  
дарга)

Д.Бөхболд (Байгаль орчны газрын орчны мэргэжилтэн)

Ц.Билгүүн (Хот тохижуулах газрын дарга)

Б.Золбаяр (Хот тохижуулах газрын дендрологич)

Д.Баяржавхлан (Жаргалант сумын Засаг даргын Тамгын  
газрын Байгаль орчны асуудал хариуцсан  
мэргэжилтэн)

Нарийн бичгийн  
дарга:

Э.Оюунтунгалаг (Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн  
бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн  
Байгаль орчин, уул уурхай, хүнд үйлдвэрийн  
асуудал хариуцсан мэргэжилтэн)

-оОо-

Засаг даргын 2025 оны  
01 дүгээр сарын 03-ны өдрийн  
А/06 дугаар захирамжийн  
нэгдүгээр хавсралт

**ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ (ТЕХНИК ТОНОГ  
ТӨХӨӨРӨМЖ) ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР,  
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ**

Ажлын хэсгийн

ахлагч: Э.Уртнасан (Засаг даргын орлогч)

Б.Амартүвшин (Жаргалант сумын Засаг дарга)

Б.Цогтсайхан (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын  
газрын Кадастрын хэлтсийн дарга)

А.Цэен-Ойдов (Байгаль орчны газрын Орчны бохирдлын  
асуудал хариуцсан мэргэжилтэн)

Д.Бумцэнд ("Шинэ Ховд Жаргалант ТҮК" ОНӨААТҮГ-ын дарга)

Д.Баяржавхлан (Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын  
Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн

дарга: Э.Оюунтунгалаг (Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн  
бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн  
Байгаль орчин, уул уурхай, хүнд үйлдвэрийн  
асуудал хариуцсан мэргэжилтэн)

-оОо-